



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 1/129

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнсний ногоо худалдаалах тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор төв магистрал зам дагуу худалдааны цэг бий болгох зорилгоор хүнсний ногоо худалдаалах зөөврийн сууцны зардалд 7.000.000 (долоон сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ХАТАНБААТАР

